

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрчим хүчний яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/055НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он	Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegst@audit.gov.mn Аудитын менежер: Б.Долгорсүрэн Утас: 261885 Цахим хаяг: dolgorsurenb@audit.gov.mn Ахлах аудитор: С.Отгонхорлоо Утас: 261740 Цахим хаяг: otgonkhorloos@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Н.ТАВИНБЭХ
ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 07/692
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрчим хүчний яамны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант онд 226,174.5 мянган төгрөгийн баталсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулаагүй, 48,062.5 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй, 3,829,543.5 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг болон татаасыг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй зэрэг асуудал нь бидний тогтоосон 904,123.5 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Асуудлыг онцолсон тэмдэглэсэн хэсэг

Засгийн газрын 2017 оны 199 дүгээр тогтоолоор баталсан “Гэр хорооллын айл өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлт үзүүлэх журам”, “Өвлийн хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх зарим арга хэмжээ авах тухай” 2018 оны 324 дүгээр тогтоолыг үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 483, 2023 оны 724 дүгээр тогтоолоор дээд хязгаараас давсан хэрэглээний тарифт 50 хувийн хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээнд нийт 90,521.5 мянган төгрөгийн хөнгөлөлтийг төрөөс үзүүлсэн байна.

Z:\Yawsan_Bichig\2025\0225 SNAG-51.Docx

1525070732

Аудитын гол асуудал

Эрчим хүчний яамны урсгал төсөвт Засгийн газрын 2023 оны 246 тогтоолоор Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төслийн санхүүжилтийг баталж, “Эрх шилжүүлэх тухай” Эрчим хүчний сайдын 2024 оны А/111 дүгээр тушаалаар Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын Цэцэгт, Шар цэхээ, Баян нуур багт 7,891,117.8 мянган төгрөг, Увс аймгийн Өмнөговь суманд 3,938,145.4 мянган төгрөг, нийт 11,829,263.2 мянган төгрөгийн нэг удаагийн нүүлгэн шилжүүлэх нөхөн төлбөрийг шилжүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд Эрчим хүчний яамны урсгал төсөвт Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төслийн 1,026,900.0 мянган төгрөгийн санхүүжилтийг баталж, гүйцэтгэлээр тус Эрчим хүчний Сайдын 2024 оны А/78, А/223 дугаар тушаалаар байгаль орчны менежментийн зардалд 801,213.2 мянган төгрөгийг зарцуулсан байна. Мөн Сайдын 2024 оны А/27 дугаар тушаалаар Эгийн голын усан цахилгаан станц ТӨХХК-ийн эдийн засгийн зорилтот түвшнийг 1,003,250.7 мянган төгрөгөөр баталж, 835,295.8 мянган төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэлээр санхүүжүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	174,931,278.04	219,039,622.58
33	АВЛАГА	12,959,074.46	48,062,559.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	12,959,074.46	48,062,559.00
33101	Цалингийн авлага	12,959,074.46	48,062,559.00
35	БАРАА МАТЕРИАЛ	161,972,203.58	170,977,063.58
35400	Хангамжийн материал	161,972,203.58	170,977,063.58
35410	Бичиг хэргийн материал	12,143,640.00	13,689,370.00
35430	Сэлбэг хэрэгсэл	6,691,600.00	6,177,500.00
35440	Түлш, шатах тослох материал	3,242,132.00	5,332,332.00
35470	Бусад хангамжийн материал	139,894,831.58	145,777,861.58
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	4,632,354,621.12	4,464,042,691.56
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,632,354,621.12	4,464,042,691.56
39200	Биет хөрөнгө	4,294,356,338.43	4,174,886,488.83
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,562,406,169.62	3,562,406,169.62
39202	Хуримтлагдсан элэгдэл - Барилга	(612,698,937.13)	(711,106,977.85)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	172,125,036.00	172,125,036.00
39204	Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл	(30,531,251.00)	(59,218,757.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	757,236,259.17	755,265,621.43
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	(445,058,525.55)	(370,802,174.06)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	281,684,129.10	187,099,959.45
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(206,327,253.49)	(134,755,982.77)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,068,436,776.26	1,040,960,839.57
39215	Хуримтлагдсан элэгдэл - Бусад үндсэн хөрөнгө	(252,916,064.55)	(267,087,245.56)
39300	Биет бус хөрөнгө	337,998,282.69	289,156,202.73
39301	Програм хангамж	50,842,080.00	50,842,080.00
39302	Хуримтлагдсан элэгдэл - Програм хангамж	(583,333.31)	(49,425,413.27)
39303	Бусад биет бус хөрөнгө	287,739,536.00	287,739,536.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	4,807,285,899.16	4,683,082,314.14
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	4,807,285,899.16	4,683,082,314.14
51	Засгийн газрын хувь оролцоо	4,807,285,899.16	4,683,082,314.14
51101	-Төрийн	3,271,431,489.68	3,271,431,489.68
51200	Хуримтлагдсан үр дүн	263,741,484.39	139,537,899.37
51210	Өмнөх үеийн үр дүн	377,183,212.86	263,741,484.39
51220	Тайлант үеийн үр дүн	(113,441,728.47)	(124,203,585.02)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,272,112,925.09	1,272,112,925.09
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	4,807,285,899.16	4,683,082,314.14

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

			/Төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	90,298,914,461.64	241,026,891,831.56	
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	35,014,043.64	33,870,647.56	
1200	Нийтлэг татварын бус орлого	35,014,043.64	33,870,647.56	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,279,148.00	1,688,544.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	1,279,148.00	1,688,544.00	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	33,315,245.64	32,182,103.56	
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Материал	419,650.00	-	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	90,263,900,418.00	240,993,021,184.00	
1310	Улсын төсвөөс	86,841,600,418.00	240,993,021,184.00	
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	86,783,305,620.00	240,916,703,054.00	
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	58,294,798.00	76,318,130.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,422,300,000.00	-	
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	3,422,300,000.00	-	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	90,412,356,190.11	241,151,095,416.58	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	90,412,356,190.11	241,151,095,416.58	
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,565,320,145.02	6,933,420,781.72	
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	2,892,421,351.29	3,827,167,790.76	
210101	Үндсэн цалин	1,863,954,505.99	2,379,958,063.18	
210102	Нэмэгдэл	535,039,316.05	747,412,587.37	
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	222,139,000.00	371,208,000.00	
210104	Урамшуулал	271,288,529.25	328,589,140.21	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	370,742,414.32	481,862,060.71	
210201	Тэтгэврийн даатгал	254,289,667.21	329,533,550.58	
210202	Тэтгэмжийн даатгал	30,027,942.65	38,983,292.15	
210203	ҮОМШӨ-ний даатгал	23,166,610.89	19,538,047.20	
210204	Ажилгүйдлийн даатгал	5,666,441.21	18,723,664.05	
210205	Эрүүл мэндийн даатгал	57,591,752.36	75,083,506.73	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	113,516,731.58	93,851,618.13	
210301	Гэрэл, цахилгаан	82,813,103.40	70,926,437.80	
210302	Түлш, халаалт	25,497,895.64	17,220,195.92	
210303	Цэвэр, бохир ус	5,205,732.54	5,704,984.41	
2104	Хангамж, бараа материалын зардал	86,523,950.24	90,470,097.00	
210401	Бичиг хэрэг	23,437,755.00	32,286,473.00	
210402	Тээвэр, шатахуун	884,400.00	7,909,800.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	29,846,681.26	32,501,100.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,260,000.00	900,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,395,561.00	16,872,724.00	
210408	Бараа материал акталсны зардал	14,699,552.98	-	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,850,500.00	134,608,615.00	
210604	Урсгал засвар	22,850,500.00	134,608,615.00	
2107	Томилолт, зочны зардал	14,359,092.00	151,079,903.00	
210702	Дотоод албан томилолт	14,359,092.00	151,079,903.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,232,564,633.00	1,665,012,020.00	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,221,601,494.00	1,636,509,065.00	
210803	Даатгалын үйлчилгээ	1,940,000.00	5,391,970.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	356,189.00	335,703.00	
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	-	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,393,000.00	20,888,000.00	
210807	Газрын төлбөр	2,089,950.00	1,884,282.00	

**Эрчим хүчний яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын хураангуй тайлан**

210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	5,129,000.00	3,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,832,341,472.59	489,368,677.12
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,532,121,745.00	123,266,456.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	300,219,727.59	366,102,221.12
212	ТАТААС	72,499,949,318.67	221,621,474,900.80
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	72,499,949,318.67	221,621,474,900.80
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	72,499,949,318.67	221,621,474,900.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,347,086,726.42	12,596,199,734.06
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	4,041,440.60	4,619,696.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	4,041,440.60	4,619,696.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,612,725,722.00	11,978,897,248.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,680,000.00	20,100,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,558,024,546.00	11,901,263,254.00
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	45,021,176.00	57,533,994.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	730,319,563.82	612,682,790.06
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	730,319,563.82	612,682,790.06
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(113,441,728.47)	(124,203,585.02)
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	(113,441,728.47)	(124,203,585.02)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

			/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	90,264,962,590.00	240,995,229,194.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	79,148.00	2,208,010.00
1200	Нийтлэг татварын бус орлого	79,148.00	2,208,010.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	79,148.00	724.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	79,148.00	724.00
120009	Бусад нийтлэг татварын бус орлого	-	2,207,286.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	90,264,883,442.00	240,993,021,184.00
1310	Улсын төсвөөс	86,842,583,442.00	240,993,021,184.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	86,783,305,620.00	240,916,703,054.00
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	59,277,822.00	76,318,130.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,422,300,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	3,422,300,000.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	90,125,044,550.00	240,829,621,006.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	90,125,044,550.00	240,829,621,006.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,278,008,504.91	6,611,946,371.14
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	2,892,900,674.75	3,826,688,467.30
210101	Үндсэн цалин	1,864,815,551.79	2,377,336,499.19
210102	Нэмэгдэл	535,039,316.05	749,180,696.96
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	222,095,012.00	371,408,363.64
210104	Урамшуулал	270,950,794.91	328,762,907.51
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	370,742,414.32	481,862,060.71
210201	Тэтгэврийн даатгал	254,289,667.21	329,533,550.58
210202	Тэтгэмжийн даатгал	30,027,942.65	38,983,292.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	23,166,610.89	19,538,047.20
210204	Ажилгүйдлийн даатгал	5,666,441.21	18,723,664.05
210205	Эрүүл мэндийн даатгал	57,591,752.36	75,083,506.73
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	113,516,731.58	93,851,618.13
210301	Гэрэл, цахилгаан	82,813,103.40	70,926,437.80
210302	Түлш, халаалт	25,497,895.64	17,220,195.92
210303	Цэвэр, бохир ус	5,205,732.54	5,704,984.41
2104	Хангамж, бараа материалын зардал	80,265,565.26	90,942,206.00
210401	Бичиг хэрэг	23,691,895.00	25,103,723.00
210402	Тээвэр, шатахуун	3,000,000.00	10,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	29,846,681.26	32,501,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,260,000.00	900,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	22,466,989.00	22,437,383.00
2105	Нормативд зардал	657,000.00	246,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	657,000.00	246,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	34,364,800.00	141,423,646.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,423,600.00	2,908,531.00
210604	Урсгал засвар	28,941,200.00	138,515,115.00
2107	Томилолт, зочны зардал	14,359,092.00	151,079,903.00
210702	Дотоод албан томилолт	14,359,092.00	151,079,903.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,255,022,633.00	1,671,717,020.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,221,601,494.00	1,636,509,065.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,940,000.00	5,391,970.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	356,189.00	335,703.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	15,665,000.00	26,960,000.00
210807	Газрын төлбөр	2,089,950.00	1,884,282.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	13,315,000.00	636,000.00

Эрчим хүчний яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,516,179,594.00	154,135,450.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,516,179,594.00	154,135,450.00
212	ТАТААС	72,499,949,318.67	221,621,474,900.80
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	72,499,949,318.67	221,621,474,900.80
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	72,499,949,318.67	221,621,474,900.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,347,086,726.42	12,596,199,734.06
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	4,041,440.60	4,619,696.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	4,041,440.60	4,619,696.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,612,725,722.00	11,978,897,248.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,680,000.00	20,100,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,558,024,546.00	11,901,263,254.00
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	45,021,176.00	57,533,994.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	730,319,563.82	612,682,790.06
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	730,319,563.82	612,682,790.06
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)	139,918,040.00	165,608,188.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	139,918,040.00	165,608,188.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	139,918,040.00	165,608,188.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	139,918,040.00	165,608,188.00
2251	Үндсэн хөрөнгө олж бэлтгэхэд төлсөн	139,918,040.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	139,918,040.00	165,608,188.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)	(139,918,040.00)	(165,608,188.00)
9	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	-	-
10	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)	-	-
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,271,431,489.68	1,189,987,889.09	377,183,212.86	4,838,602,591.63
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,271,431,489.68	1,189,987,889.09	377,183,212.86	4,838,602,591.63
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	82,125,036.00	-	82,125,036.00
Тайлант үеийн үр дүн	-	-	(113,441,728.47)	(113,441,728.47)
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,271,431,489.68	1,272,112,925.09	263,741,484.39	4,807,285,899.16
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,271,431,489.68	1,272,112,925.09	263,741,484.39	4,807,285,899.16
Тайлант үеийн үр дүн	-	-	(124,203,585.02)	(124,203,585.02)
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,271,431,489.68	1,272,112,925.09	139,537,899.37	4,683,082,314.14

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
70906	Эрчих хүч, уул уурхайн бодлого, удирдлага	242,170,087,200.00	240,306,278,273.94	1,863,808,926.06	99.2
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	5,578,094,200.00	5,139,825,964.14	438,268,235.86	92.1
12	Татварын бус орлого	5,578,094,200.00	5,578,094,200.00	-	100.0
12200	Тусламжийн орлого	5,578,094,200.00	5,578,094,200.00	-	100.0
122005	Төсвөөс санхүүжих	5,578,094,200.00	5,578,094,200.00	-	100.0
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,578,094,200.00	5,139,825,964.14	438,268,235.86	92.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,578,094,200.00	5,139,825,964.14	438,268,235.86	92.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,578,094,200.00	5,139,825,964.14	438,268,235.86	92.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,097,499,300.00	3,825,468,937.30	272,030,362.70	93.4
210101	Үндсэн цалин	2,399,863,800.00	2,377,336,499.19	22,527,300.81	99.1
210102	Нэмэгдэл	1,056,719,600.00	749,180,696.96	307,538,903.04	70.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	391,713,300.00	371,408,363.64	20,304,936.36	94.8
210104	Урамшуулал	249,202,600.00	327,543,377.51	(78,340,777.51)	131.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	549,687,400.00	481,862,060.71	67,825,339.29	87.7
210201	Тэтгэврийн даатгал	373,787,400.00	329,533,550.58	44,253,849.42	88.2
210202	Тэтгэмжийн даатгал	43,975,000.00	38,983,292.15	4,991,707.85	88.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	21,987,500.00	19,538,047.20	2,449,452.80	88.9
210204	Ажилгүйдлийн даатгал	21,987,500.00	18,723,664.05	3,263,835.95	85.2
210205	Эрүүл мэндийн даатгал	87,950,000.00	75,083,506.73	12,866,493.27	85.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	145,425,400.00	93,851,618.13	51,573,781.87	64.5
210301	Гэрэл, цахилгаан	107,439,200.00	70,926,437.80	36,512,762.20	66.0
210302	Түлш, халаалт	28,062,700.00	17,220,195.92	10,842,504.08	61.4
210303	Цэвэр, бохир ус	9,923,500.00	5,704,984.41	4,218,515.59	57.5
2104	Хангамж, бараа материалын зардал	106,311,700.00	90,942,206.00	15,369,494.00	85.5
210401	Бичиг хэрэг	27,001,000.00	25,103,723.00	1,897,277.00	93.0
210402	Тээвэр, шатахуун	14,731,400.00	10,000,000.00	4,731,400.00	67.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	32,501,100.00	32,501,100.00	-	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,230,900.00	900,000.00	2,330,900.00	27.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	28,847,300.00	22,437,383.00	6,409,917.00	77.8
2105	Норматив зардал	1,122,100.00	246,000.00	876,100.00	21.9
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,122,100.00	246,000.00	876,100.00	21.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	325,023,300.00	307,031,834.00	17,991,466.00	94.5
210601	Багаж, техник хэрэгсэл	184,506,500.00	168,516,719.00	15,989,781.00	91.3
210604	Урсгал засвар	140,516,800.00	138,515,115.00	2,001,685.00	98.6
2107	Томилолт, зочны зардал	152,720,000.00	151,079,903.00	1,640,097.00	98.9
210702	Дотоод албан томилолт	152,720,000.00	151,079,903.00	1,640,097.00	98.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	45,329,400.00	35,207,955.00	10,121,445.00	77.7
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,325,200.00	-	1,325,200.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	5,403,100.00	5,391,970.00	11,130.00	99.8
210804	Тээврийн хэрэгслийн татвар	341,200.00	335,703.00	5,497.00	98.4
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	77,000.00	-	77,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	26,960,000.00	26,960,000.00	-	100.0
210807	Газрын төлбөр	2,376,200.00	1,884,282.00	491,918.00	79.3
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	8,846,700.00	636,000.00	8,210,700.00	7.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	154,975,600.00	154,135,450.00	840,150.00	99.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	154,975,600.00	154,135,450.00	840,150.00	99.5
80419	Эрчим хүчний алдагдлын татаас	221,622,946,300.00	221,621,474,900.80	1,471,399.20	100.0
12	Татварын бус орлого	221,622,946,300.00	221,622,946,300.00	-	100.0
12200	Тусламжийн орлого	221,622,946,300.00	221,622,946,300.00	-	100.0
122005	Төсвөөс санхүүжих	221,622,946,300.00	221,622,946,300.00	-	100.0

Эрчим хүчний яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	221,622,946,300.00	221,621,474,900.80	1,471,399.20	100.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	221,622,946,300.00	221,621,474,900.80	1,471,399.20	100.0
212	ТАТААС	221,622,946,300.00	221,621,474,900.80	1,471,399.20	100.0
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	221,622,946,300.00	221,621,474,900.80	1,471,399.20	100.0
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	221,622,946,300.00	221,621,474,900.80	1,471,399.20	100.0
80509	Гадаадын болон олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	5,297,400.00	4,619,696.00	677,704.00	87.2
12	Татварын бус орлого	5,297,400.00	5,297,400.00	-	100.0
12200	Тусламжийн орлого	5,297,400.00	5,297,400.00	-	100.0
122005	Төсвөөс санхүүжих	5,297,400.00	5,297,400.00	-	100.0
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,297,400.00	4,619,696.00	677,704.00	87.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,297,400.00	4,619,696.00	677,704.00	87.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,297,400.00	4,619,696.00	677,704.00	87.2
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	5,297,400.00	4,619,696.00	677,704.00	87.2
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	5,297,400.00	4,619,696.00	677,704.00	87.2
80704	Ахмад дайчин, алдар цолтой ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламж	73,575,000.00	72,000,000.00	1,575,000.00	97.9
12	Татварын бус орлого	73,575,000.00	73,575,000.00	-	100.0
12200	Тусламжийн орлого	73,575,000.00	73,575,000.00	-	100.0
122005	Төсвөөс санхүүжих	73,575,000.00	73,575,000.00	-	100.0
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	73,575,000.00	72,000,000.00	1,575,000.00	97.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	73,575,000.00	72,000,000.00	1,575,000.00	97.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	73,575,000.00	72,000,000.00	1,575,000.00	97.9
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	73,575,000.00	72,000,000.00	1,575,000.00	97.9
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	112,126,900.00	77,633,994.00	34,492,906.00	69.2
12	Татварын бус орлого	112,126,900.00	112,126,900.00	-	100.0
12200	Тусламжийн орлого	112,126,900.00	112,126,900.00	-	100.0
122005	Төсвөөс санхүүжих	112,126,900.00	112,126,900.00	-	100.0
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	112,126,900.00	77,633,994.00	34,492,906.00	69.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	112,126,900.00	77,633,994.00	34,492,906.00	69.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	112,126,900.00	77,633,994.00	34,492,906.00	69.2
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	53,290,000.00	20,100,000.00	33,190,000.00	37.7
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	58,836,900.00	57,533,994.00	1,302,906.00	97.8
80814	Төрөөс иргэдэд үзүүлэх бусад тэтгэмж, дэмжлэг	13,082,647,400.00	11,829,263,254.00	1,253,384,146.00	90.4
12	Татварын бус орлого	13,082,647,400.00	11,829,263,254.00	1,253,384,146.00	90.4
12200	Тусламжийн орлого	13,082,647,400.00	11,829,263,254.00	1,253,384,146.00	90.4
122005	Төсвөөс санхүүжих	13,082,647,400.00	11,829,263,254.00	1,253,384,146.00	90.4
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	13,082,647,400.00	11,829,263,254.00	1,253,384,146.00	90.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,082,647,400.00	11,829,263,254.00	1,253,384,146.00	90.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,082,647,400.00	11,829,263,254.00	1,253,384,146.00	90.4
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	13,082,647,400.00	11,829,263,254.00	1,253,384,146.00	90.4
83105	Төсөл, арга хэмжээний бэлтгэл хангах	1,695,400,000.00	1,561,460,465.00	133,939,535.00	92.1
12	Татварын бус орлого	1,695,400,000.00	1,695,400,000.00	-	100.0
12200	Тусламжийн орлого	1,695,400,000.00	1,695,400,000.00	-	100.0
122005	Төсвөөс санхүүжих	1,695,400,000.00	1,695,400,000.00	-	100.0
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,695,400,000.00	1,561,460,465.00	133,939,535.00	92.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,695,400,000.00	1,561,460,465.00	133,939,535.00	92.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,695,400,000.00	1,561,460,465.00	133,939,535.00	92.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	1,695,400,000.00	1,561,460,465.00	133,939,535.00	92.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,695,400,000.00	1,561,460,465.00	133,939,535.00	92.1

Эрчим хүчний яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын хураангуй тайлан

12000	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	610,424,780.06	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	110	101	-9	
620001	Удирдах ажилтан	2	2	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	96	87	-9	
620003	Үйлчлэх ажилтан	12	12	-	100.0

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1. Аудитаар илэрсэн нийт 4,128.0 мянган төгрөгийн 2 алдааг аудитын явцад залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгө бэлтгэсэн дүнг 2,908.5 төгрөгөөр илүү илэрхийлсэн.	1	2,908.5			1	2,908.5	1	2,908.5				
2	Илүү олгосон урамшууллыг буцааж байгууллагын дансанд тушаасан боловч урамшууллын зардлыг бууруулж тайлагнаагүй	1	1,219.5			1	1,219.5	1	1,219.5				
Дүн		2	4,128.0	-	-	2	4,128.0	2	4,128.0	-	-	-	-

3.2. Аудитаар нийт 4,176,873.1 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 3,993,362.2 мянган төгрөгийн 4 албан шаардлага хүргүүлж, 183,510.8 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Эрчим хүчний яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

1	Байгууллагаас 2019 онд ажлаас халагдсан ажилтанд илүү олгосон цалингийн 207.4 мянган төгрөгийн, Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2022 оны 183/ШШ2022/03094 дүгээр захирамжийн дагуу олгох 2019 оноос хойших ажилгүй байх хугацааны цалингийн 37,790,0 мянган төгрөгийн, Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2021 оны 128/ШШ2021/0032 дугаар захирамжийн дагуу олгох цалингийн 10,065.2 мянган төгрөгийн, нийт нийт 48,062.5 мянган төгрөгийн авлагыг буруутай шийдвэр гаргасан албан тушаалтнаар төлүүлэх арга хэмжээг аваагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажгаагүй байна.	1	48,062.5			1	48,062.5					
2	Эрчим хүчний яамны баланст бүртгэлтэй 73,092.5 мянган төгрөгийн өртөгтэй газрыг Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төвөөс "Балансаас баланст шилжүүлэх тухай" Засгийн газрын 2022 оны 318 дугаар тогтоолоор шилжүүлэн авсан боловч газрын гэрчилгээгүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	1	73,092.5			1	73,092.5					
3	Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 230 нэр төрлийн 47,173.4 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмжийг дахин үнэлээгүй байна.	1	-					1	-			
4	Тайлант онд олгосон ЭХЯ-ны санхүүгийн нэгтгэсэн тайланд санхүүгийн тайланг нэгтгэдэггүй 7 байгууллагад 1,000,000.0 мянган төгрөгийн эрчим хүч, халаалтын үнийн тарифын татаас, 82,348.6 мянган төгрөгийн өвлийн хүлэмжийн тарифын хөнгөлөлтийн татаас, 2,747,194.9 мянган төгрөгийн гэр хорооллын айл өрхийн шөнийн тарифын хөнгөлөлтийн татаас, нийт 3,829,543.6 мянган төгрөгийн татаас	1	3,829,543.6			1	3,829,543.6					

Эрчим хүчний яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын хураангуй тайлан

	олгож, тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.											
5	Эрчим хүчний сайдын 2024 оны А/200, А/221, А/309, А/310 дугаар тушаалыг тус тус үндэслэн 133,165,660.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгохоор баталснаас, гүйцэтгэлээр 131,100,028.4 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгийг олгож, ЭХС-ын 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/221 дүгээр тушаалаар "Санхүүгийн дэмжлэг олгох" 2024 оны А/200 дугаар тушаалд нэмэлт өөрчлөлт оруулж, Эрчим хүчний үндэсний төвд 120,000.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож, санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу хуваарилаагүй байна.	1	120,000.0				1	120,000.0				
6	Дотоод томилолтоор явахдаа Эрчим хүчний үндэсний төвөөс автомашин захиалж, тус яамнаас шатахуун зардлыг зарцуулснаас жолоочийн тооцооны хуудас байхгүй, томилолтын дараа тооцоог бодож, хянаж хаагаагүй байна.	1	12,690.6				1	12,690.6				
7	Сөүлсэниорс товер ХХК-тай гэрээ байгуулж, тайлант онд нийт 102 ажилтныг эрүүл мэндийн үзлэгт хамруулан 50,820.2 мянган төгрөгийн шилжүүлж, ЭХС-ын 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй арга хэмжээг санхүүжүүлсэн байна.	1	50,820.2				1	50,820.2				
8	Эрчим хүчний реформ зохион байгуулахдаа ЭХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/201 дүгээр тушаалыг үндэслэн Туушин зочид буудал ХХК-тай гэрээ байгуулж, тоног төхөөрөмж болон заалыг нэг өдөр түрээсэлж, баталсан төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.	1	42,663.6			1	42,663.6					
Дүн		8	4,176,873.0	-	-	4	3,993,362.2	4	183,510.8	-	-	-

Эрчим хүчний яамны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын хураангуй тайлан

3.3. АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн нийцлийн асуудлаар шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой албан шаардлага 1, бусад хууль тогтоомжтой холбоотой зөвлөмж 1 өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
1	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг байршуулахаас 9, 10, 11 дүгээр сард орлогын 153,769,118.7 мянган төгрөгийн 20 гүйлгээ, зарлагын 3,851,285.1 мянган төгрөгийн 15 гүйлгээг байршуулаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна.	1	-			1	-		
Дүн		1	-	-	-	1	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
1	"Эрчим хүч, үйлдвэрлэхэд ашиглах түлшний үнийн тооцоог хянах тухай" Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 592, 593, 594 дүгээр тогтоолын дагуу Эрчим хүчний сайдын 2024 оны А/311 дүгээр тушаалаар 90,521,473.5 мянган төгрөгийн эрчим хүч, дулааны алдагдлын үнийн тариф болон агаарын бохирдол/гэр хорооллын айл өрхийн шөнийн тарифын хөнгөлөлт/-ийг өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн олгосон гэсэн боловч алдагдлыг нөхөх татаасны хуваарилав, хяналтыг хэрхэн хэрэгжүүлсэн нь тодорхойгүй байна.							1	-
Дүн		-	-	-	-	-	-	1	-
Нийт дүн		1	-	-	-	1	-	1	-